



БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ЭДЭЛБЭРИЙН  
ЗАСАГЛАЛЫН САЙН ДУРЫН ЗӨВЛӨМЖ

# ТОЙМ



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР  
ХҮНС, ХӨДӨӨ  
АЖ АХУЙН ЯАМ



ХҮН ТӨВТЭЙ  
БАЙГАЛЬ  
ХАМГААЛАЛ 1



# БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ЭДЭЛБЭРИЙН ЗАСАГЛАЛЫН САЙН ДУРЫН ЗӨВЛӨМЖ

## ТОЙМ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага (ХХААБ)  
болон Хүн Төвтэй Байгаль Хамгаалал (ХТБХ) ТББ-ын  
харилцан тохиролцлын үндсэн дээр хэвлэн гаргав.

НҮБ-ЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГА  
**Ром хот, 2012 он**

Энэхүү материал нь анхлан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага (ХХААБ)-аас “VOLUNTARY GUIDELINES ON THE GOVERNANCE OF TENURE At a glance” нэртэйгээр англи хэл дээр хэвлэгдсэн. Монгол хэлний хөрвүүлгийг Хүн Төвтэй Байгаль Хамгаалал ТББ (ХТБХ) хариуцан гүйцэтгэсэн. Зөрүү гарсан тохиолдолд анхны хэл дээрх хувийг албан ёсны гэж үзнэ.

Энэхүү материалд ашигласан тайлбар, тодорхойлолт нь аливаа улс орон, газар нутаг, хот суурин газар, тэдгээрийн захиргааны байгууллага, хил хязгаарын хуулийн болон хөгжлийн төлөвийн талаархи НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагын (ХХААБ) аливаа үзэл, баримтлалыг агуулаагүй болно. Энэ материалд патент бүхий аливаа компани, үйлдвэрлэгчийг дурьдсан нь ижил төстэй үйл ажиллагаа эрхлэгч бусадтай харьцуулан санал болгож байгаа гэсэн үг биш юм.

© Хүн Төвтэй Байгаль Хамгаалал, (2015) (Монгол хэлний орчуулга)

© ХХААБ [2012] (Англи хэвлэл)

Орчуулагч Н.Лхамдулам  
Хянагч, редактор А.Оюунчимэг

*Энэхүү товхимолд Хүнсний аюулгүй байдлын хүрээнд газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн хариуцлагатай засаглалын сайн дурын зөвлөмжийг товчоор тоймлон хүргэж байна. Зөвлөмжийн ойлголтонд дараах байдлаар туслахад чиглэгдсэн болно.*

Үүнд:

- Үндсэн нэр томьёо, үзэл баримтлалыг тодорхойлох
- Зөвлөмжийн зорилгыг тайлбарлах
- Зөвлөмжийн агуулгыг тоймлон хүргэх
- Зөвлөмж нь хүний эрхтэй хэрхэн уялдаж буйг тайлбарлах
- Зөвлөмжийг хэн, хэрхэн ашиглах болох талаар тодорхойлох

**Тус товхимол нь Зөвлөмжийг орлохгүй бөгөөд Зөвлөмжийн товч эмхэтгэл биш болно.**

Зөвлөмжийн цахим хувилбарыг [www.fao.org/nr/tenure](http://www.fao.org/nr/tenure) гэсэн хаягаар орж үзнэ үү.

## Зөвлөмж ямар зорилготой вэ?

Зөвлөмж нь төрийн, хувийн, нийтийн, хамтын, уугуул болон уламжлалт зэрэг бүхий л хэлбэрийн газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн хариуцлагатай засаглалыг дэмждэг.

Зөвлөмжийн эрхэм зорилго нь бүх нийтийн хүнсний аюулгүй байдлыг хангах болон үндэсний хүнсний аюулгүй байдлын бодлогын хүрээнд зохих хэмжээний хангалттай хүнстэй байх эрхийг системтэйгээр баталгаажуулах явдлыг дэмжих юм. Зөвлөмж нь өлсгөлөн, ядуурлыг арилгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн бөгөөд тогтвортой амьжиргаа, нийгмийн тогтвортой байдал, орон сууцны баталгаа, хөдөөгийн хөгжил, байгаль хамгаалал болон нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгыг агуулсан болно. Зөвлөмжид эмзэг болон нийгмээс гадуурхагдсан хүмүүсийн тухай илүү дурьдагдсан ч нийт хүмүүсийн ашиг сонирхолд үйлчлэх зорилготой.

Зөвлөмж нь эдэлбэрийн хариуцлагатай засаглалыг хөгжүүлэхэд баримтлах зарчмууд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг тодорхойлж байгаа юм. Төрөөс стратеги, бодлого, хууль, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа ашиглаж болохуйц үндсэн санаануудыг агуулсан бичиг баримтууд юм. Мөн Зөвлөмж нь засгийн газар, иргэний нийгэм, хувийн хэвшил болон иргэдийн өөрсдийн болон бусдын хийхээр төлөвлөж буй үйл ажиллагаанууд нь хүлээн зөвшөөрөгдсөн практик мөн эсэхийг шүүн тунгаах боломж олгоно.

# Эдэлбэрийн засаглал өлсгөлөн, ядууралд хэрхэн нөлөөлдөг вэ?

Өлсгөлөн, ядуурлыг арилгах хийгээд байгаль орчны тогтвортой ашиглалт нь хүмүүс, нутгийн иргэд, бусад хэрэглэгчид газар, загас, ойн нөөцийг хэрхэн олж авч байгаагаас ихээхэн шалтгаалдаг. Байгалийн нөөцөөс хүртэх, ашиглахтай холбоотой асуудлууд нь эдэлбэрийн системээр тодорхойлогдон, зохицуулагдана.

Дэлхийн өсөн нэмэгдэж буй хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах шаардлага болон байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас газар, загас, ойн нөөцийн хүрэлцээ буурч байгаатай холбоотойгоор эдэлбэрийн системд тулгарах хүндрэл бэрхшээлүүд нэмэгдсээр байна. Эдэлбэрийн эрх хангалтгүй, баталгаагүй байгаа нь эмзэг байдал, өлсгөлөн, ядуурлыг нэмэгдүүлж, байгалийн нөөцийн эзэмшлийн төлөө өрсөлдөөнийг зөрчилдөөн болгон хувиргаж, байгаль орчны доройтолд хүргэх нөхцлийг бүрдүүлж байна.

Эдэлбэрийн засаглал нь хүмүүс, нутгийн иргэд болон бусад хэрэглэгчдэд газар, загас, ойн нөөцийг ашиглах, хянах эрх, үүргийг хэрхэн, яаж олгох боломжтойг тодорхойлоход чухал үүрэгтэй.

## Эдэлбэр гэсэн нэр томъёог хэрхэн ойлгох вэ?

Эдэлбэрийн систем нь хүмүүс, нутгийн иргэд болон бусад хэрэглэгчдэд байгалийн нөөцийг хуулийн дагуу болон албан бус зохицуулалтаар хэрхэн хүртээмжтэй болгох асуудлыг тодорхойлж, зохицуулж өгдөг. Эдэлбэрийн системийн дүрэм, журмаар хэн ямар нөөцийг, хэдий хугацаагаар, ямар нөхцөлтэйгээр ашиглаж болохыг тодорхойлдог. Эдгээр нь батлагдсан бодлого, хуулиуд болон бичигдээгүй хууль, тухайлбал ёс заншил, бодит амьдрал дээр үндэслэсэн байж болно.

# Эдэлбэрийн хариуцлагатай засаглалын жишээ

Эдэлбэрийн хариуцлагатай засаглал болон түүний гүйцэтгэлийн талаарх олон жишээг дэлхийн туршлагаас харж болно. Судалгаанаас үзэхэд өндөр ашиг орлоготой, бага орлоготой улс орнууд гээд дэлхийн бүх бүс нутагт эдэлбэрийн засаглалтай холбоотой асуудлууд ямар нэгэн байдлаар гарч байдаг байна. Эдэлбэрийн засаглалтай холбоотой дийлэнхи асуудлууд сул засаглалаас үүдэлтэй байдаг ба эдгээр асуудлуудыг шийдвэрлэх оролдлогууд засаглалын хариуцлагагүй байдлаас болж бүтэлгүйтэх тохиолдол гардаг.

## Сул засаглал

- Шийдвэр гаргахад нөлөөлөх улс төрийн хүчин мөхөс, авилгад автсан албан тушаалтнуудыг хахуульдах санхүүгийн чадавхигүй ядуусыг гадуурхахдад хүргэдэг
- Нийгэм, эдийн засгийн хувьд хэдийнээ гадуурхагдсан эмэгтэйчүүдийг улам эмзэг болгодог
- Хөрөнгө оруулалтыг үргээж ингэснээрээ эдийн засгийн өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлдэг
- Хүмүүст байгалийн нөөцийг хэтрүүлэн ашиглаж хөлжих боломж олгосноор байгаль орчны тогтвортой байдлыг аюулд оруулдаг

## Хариуцлагатай засаглал

- Газар, загас, ойн нөөцийн хүртээмжийг илүү эрх тэгш болгодог
- Хүмүүсийн эдэлбэрийн эрх зохисгүйгээр түүний дотор албадан нүүлгэлтээр алдагдахаас хамгаална
- Хууль эрх зүй, бодлого, бодит үйл ажиллагааны хүрээнд хэн нэгэн алагчлагдахгүй байх нөхцөлийг хангахад тусалдаг
- Ил тод байдлаар оролцооны үндсэн дээр шийдвэр гаргахад чиглүүлдэг
- Хуулийн хэрэгжилт бүх хүмүүст тэгш эрхтэйгээр үйлчлэх нөхцөлийг хангахад тустай
- Зөрчилд хүргэлгүй маргааныг шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлдэг
- Эдэлбэрийн удирдлагын хэрэгжилтийг хялбаршуулж, хүн бүрт илүү хүртээмжтэй, илүү үр өгөөжтэй болгодог



# Зөвлөмжид ямар асуудлууд тусгагдсан бэ?

Зөвлөмжид дэлхийн хэмжээний ач холбогдол бүхий өргөн хүрээний асуудлууд тусгагдсан. Хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлаас шалтгаалан улс орнуудын засаглалыг сайжруулах тэргүүлэх ач холбогдол нь өөр өөр байж болно. Тиймээс улс орон бүр тэргүүлэх зэргийн ач холбогдолтой асуудлууд болон үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлох нь зүйтэй.

## Газар

- Өрхийн хувьд газар эзэмшлийн баталгаа нь гэр бүлийн хэрэглээний хүнсээ үйлдвэрлэх, зах зээлд борлуулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломж юм.
- Газар эдэлбэрийн баталгаат байдал нь хүнд хэцүү үед орон байр, хоол хүнс, орлоготой байх аюулгүй байдлыг хангах юм.

## Загасны аж ахуй

- Эдэлбэрийн хариуцлагатай зохицуулалт нь далай тэнгисийн болон дотоодын загасны аж ахуйгаас хамааралтай хэдэн арван сая хүний амьжиргааны баталгааны үндсэн нөхцөл болдог.
- Эдэлбэрийн эрх болон холбогдох эдэлбэрийн зохицуулалтыг сайн засаглалтай хослуулан, загасны аж ахуй болон загасчдын байгууллагын оролцоотойгоор бэхжүүлснээр загас агнуурын нөөцийг тогтвортой ашиглаж, үр ашгийн тэгш хуваарилалт хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

## Ойн аж ахуй

- Ойн нөөц нь ихэвчлэн төрийн өмчид болон хяналтанд байдаг. Ойгоос хамааралтай хүмүүс, түүний дотор нутгийн уугуул иргэдийн эдэлбэрийн эрхийг

хүлээн зөвшөөрч, хамгаалах нь ойн иргэдийн амьжиргааны баталгааны үндсэн нөхцөл юм.

- Засаглалыг сайжруулснаар (жишээ нь: хууль хэрэгжилтийн үр дүнг сайжруулж, авилгыг бууруулж, ил тод байдлыг нэмэгдүүлснээр) ойн тогтвортой менежментийг дэмжиж, хууль бус үйл ажиллагааг бууруулна.

## Салбар дундын асуудлууд

- Газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн эрхүүд хоорондоо ихэвчлэн холбоотой байдаг. Хөдөөгийн ядуучуудын олонхи нь амьжиргааны хэд хэдэн эх сурвалжтай байдаг хийгээд олон төрлийн байгалийн нөөцийн хүртээмжээс хамааралтай байдаг. (тухайлбал газар тариалан, бэлчээрийн мал аж ахуйг загасны аж ахуй болон ойн хишгээс хүртэх үйл ажиллагаатай хослуулах гэх мэт).
- Жил бүр ой бүхий газрын хэдэн сая га-г урьдчилсан зөвшөөрөлгүйгээр газар тариалангийн болон бусад газар ашиглалтын зориулалтаар ашиглаж байна. Энэ нь ойн эдэлбэрийн эрх тодорхойгүй, хуулийн хэрэгжилтийн байдал муу, авилга газар авсан, ил тод байдал дутмаг байгаа зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс улбаатай.

## Зөвлөмжид ямар асуудлууд тусгагдаагүй вэ?

Зөвлөмжид ус болон эрдэс зэрэг бусад байгалийн нөөцийн эрхийн талаар онцгойлон тусгагдаагүй. Гэсэн хэдий ч зөвлөмжийн өмнөтгөлд газар, загас, ойн нөөцийн хариуцлагатай засаглал нь ус, эрдэс баялаг зэрэг байгалийн бусад нөөцийн хүртээмж, менежменттэй салшгүй холбоотой гэдгийг онцлон тэмдэглэсэн. Үндэсний нөхцөл байдлын хүрээнд эдгээр байгалийн нөөцийн засаглалын систем, загварууд өөр өөр байж болно гэдгийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ Төрөө энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ эдгээр дагалдах байгалийн нөөцийн засаглалын асуудлыг анхаарч үзэж болох юм.

# ЗӨВЛӨМЖИЙН ТОЙМ

**БҮЛЭГ 1** Өмнөтгөлд Зөвлөмжийн ерөнхий зорилго чиглэлийг тодорхойлно.  
Хэсэг 1: Зорилго  
Хэсэг 2: Шинж чанар ба хамрах хүрээ

**БҮЛЭГ 2** **Нийтлэг үндэслэл**, эдэлбэрийн засаглалын бүхий л нөхцөл байдалд хамааралтай удирдамжаар хангана.

Хэсэг 3: **Эдэлбэрийн хариуцлагатай засаглалын үндсэн зарчим**

Хэсэг 4: **Эдэлбэртэй холбоотой эрх, үүргүүд**

Хэсэг 5: **Эдэлбэртэй холбоотой бодлого, эрх зүйн болон бүтэц-зохион байгуулалтын тогтолцоо**

Хэсэг 6: **Үйлчилгээ үзүүлэх**

**БҮЛЭГ 3** **Эдэлбэрийн эрх үүргийн зохицуулалт ба хуулийн зохицуулалт**, гэсэн энэ хэсэгт уламжлалт ёсны эдэлбэрийн системтэй уугуул болон бусад нутгийн иргэдийн эдэлбэрийн эрх, мөн түүнчлэн албан бус эдэлбэрийн эрх, хувийн хэвшлийн эзэмшилд эс бөгөөс хяналтанд байдаг газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн эрхийн анхлан хуваарилалтыг хуулиар хүлээн зөвшөөрөхтэй холбоотой асуудлуудыг хөндөнө.

Хэсэг 7: **Баталгаа**

Хэсэг 8: **Төрийн эзэмшлийн газар, загас, ойн нөөц**

Хэсэг 9: **Уламжлалт ёсны эдэлбэрийн системтэй уугуул болон бусад иргэд**

Хэсэг 10: **Албан бус эдэлбэр**

## Суурь зарчмууд

3-р хэсэгт Зөвлөмжийн суурь зарчмуудыг тусгасан. Төрөөс энэхүү ерөнхий зарчмуудтай нийцүүлж:

- Бүх зүй ёсны эдэлбэрийн эрх болон тэдгээр эрхийг эзэмшигчдийг ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, ХҮНДЭТГЭНЭ
  - Зүй ёсны эдэлбэрийн эрхүүдийг аюулаас ХАМГААЛНА
  - Зүй ёсны эдэлбэрийн эрхээ эдлэх явдлыг ДЭМЖИЖ, БОЛОМЖООР ХАНГАНА
  - Зүй ёсны эдэлбэрийн эрхийн зөрчлийг шүүхээр шийдвэрлүүлэх боломжоор ХАНГАНА
  - Эдэлбэрийн маргаан, хүч хэрэглэсэн мөргөлдөөн, авилгаас СЭРГИЙЛНЭ.
- Төрөөс бусад оролцогч талууд (бизнесийн байгууллагууд хамаарна) зүй ёсны эдэлбэрийн эрх болон хүний эрхийг хүндэтгэх үүрэгтэй.

Хэрэгжилтийн зарчмууд:

- Хүний нэр төр
- Алгчлахгүй байх
- Тэгш эрх ба шударга ёс
- Жендерийн эрх тэгш байдал
- Цогц, тууштай хандлага
- Зөвлөгөөн, оролцоо
- Хууль дүрэм
- Ил тод байдал
- Хариуцлагатай байдал
- Байнгын боловсронгуй болгох

## БҮЛЭГ 4

**Эдэлбэрийн эрх, үүргийг шилжүүлэх болон бусад өөрчлөлтүүд,** гэсэн энэ хэсэгт анх хүлээн зөвшөөрөгдсөн болон олгогдсоны дараагаар эдэлбэрийн эрхийг төрөл бүрийн хэлбэрээр шилжүүлэх буюу өөрчлөхтэй холбоотой удирдамжийг танилцуулна.

Хэсэг 11: **Зах зээл**

Хэсэг 12: **Хөрөнгө оруулалт**

Хэсэг 13: **Газрын нэгтгэл болон дахин зохион байгуулалтын арга замууд**

Хэсэг 14: **Эрх сэргээх**

Хэсэг 15: **Дахин хуваарилалтын шинэчлэлүүд**

Хэсэг 16: **Эрх цуцлах ба нөхөн олговор**

## БҮЛЭГ 5

**Эдэлбэрийн удирдлага,** гэсэн энэ хэсэгт эдэлбэрийн эрхийн үр ашигтай зохицуулалтын засаг захиргааны холбогдолтой асуудлууд тусгагдсан.

Хэсэг 17: **Эдэлбэрийн эрхийн бүртгэл**

Хэсэг 18: **Үнэлгээ**

Хэсэг 19: **Татвар ногдуулалт**

Хэсэг 20: **Зохицуулалттай орон зайн төлөвлөлт**

Хэсэг 21: **Эдэлбэрийн эрхтэй холбоотой маргаан шийдвэрлэлт**

Хэсэг 22: **Хил дамнанасан асуудлууд**

## БҮЛЭГ 6

**Уур амьсгалын өөрчлөлт болон онцгой байдлын үед авах арга хэмжээ**

Зөвлөмжийн өмнөх бүлгүүдэд голчлон “өдөр тутмын” нөхцөл байдалтай холбоотой асуудлуудыг авч үзсэн бол энэ бүлэгт хүмүүс олноор шилжин суурьшихтай холбоотой үүсэж болзошгүй онцгой нөхцөл байдлын асуудлыг авч үзнэ. Төрөөс холбогдох стратеги, үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэхдээ нүүлгэн шилжилтэд өртөх магадлалтай хүмүүстэй зөвлөлдөж, тэдний оролцоог хангаж ажиллахыг эрмэлзэх нь зүйтэй. Нүүлгэн шилжүүлэх гэж байгаа газар нь бусдын амьжиргааны эх үүсвэрийг эрсдэлд оруулах ёсгүй.

Хэсэг 23: **Уур амьсгалын өөрчлөлт**

Хэсэг 24: **Байгалийн гамшиг**

Хэсэг 25: **Газар, загас, ойн эдэлбэртэй холбоотой зөрчилдөөн**

## БҮЛЭГ 7

**Сурталчилгаа, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ,** гэсэн энэ бүлэгт Зөвлөмжинд тусгагдсан зарчмууд болон арга хэмжээнүүдийг хэрхэн сурталчилж, хэрэгжүүлж, хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт өгөх талаарх удирдамжийг тусгасан болно.

### Зөвлөмж ба жендерийн эрх тэгш байдал

Зөвлөмжид эдэлбэрийн засаглалын сул дорой байдал нь нийгэм, эдийн засгийн хувьд хэдийнээ гадуурхагдсан эмэгтэйчүүдийг илүү эмзэг байдалд хүргэдэг гэдгийг онцолсон. Зөвлөмжийн суурь зарчмуудын нэг нь жендерийн эрх тэгш байдлыг хангах гэсэн байдаг. Ихэвчлэн эмэгтэйчүүдийн газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн эрх эдлэх боломж нь бага, сул байдаг учир жендерийн эрх тэгш байдлыг хангах явдлыг сайжруулах нь чухал юм. Энэ эрх тэгш бус байдал нь албан ёсны хууль эрх зүй, уламжлалт зан заншил, нийгэм болон өрхийн түвшин дэх хөдөлмөр хуваарилалт зэрэгт ажиглагддаг ялгавартай, тэгш бус байдал зэрэг хүчин зүйлүүдээс улбаатай. Зөвлөмжид жендерийн асуудлаар тусгайлсан бүлэг байхгүй хэдий ч Зөвлөмжийн бүх хэсэгт жендерийн асуудал тусгагдсан байгаа. Эдэлбэрийн засаглалыг сайжруулах бүхий л үйл ажиллагаанд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн аль альных нь хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлыг тусгах явдлыг дэмжих үүднээс энэ аргыг ашигласан.

## Зөвлөмж, хүний эрх ба олон улсын хууль эрх зүй

Зөвлөмжид эдэлбэрийн эрхийг хүний эрхийн хүрээнд авч үзсэн. Одоогийн байдлаар эдэлбэрийн эрхийг хүний эрх хэмээн үзсэн олон улсын зөвшилцлийн гэрээ хараахан байхгүй байна. Гэсэн хэдий ч газар, загас, ойн нөөцийг олж авах боломжоор хангадаг эдэлбэрийн эрхүүд нь хоол хүнс, орон байртай байх зэрэг эрүүл мэнд, сайн сайхныг тэтгэхэд шаардлагатай амьжиргааны түвшинтэй байх эрх (Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 25-р зүйл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, 11-р зүйл) зэрэг хүний эрхийн хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой.

Эдэлбэрийн засаглал нь төрөл бүрийн хүний эрхийн хэрэгжилтэнд нөлөөлөх боломжтой. Зөвлөмжид эдэлбэр болон түүний засаглалтай холбоотой төрийн

### Зөвлөмж “зөөлөн” хууль эрх зүйн арга хэрэгсэл болох нь

Зөвлөмж нь сайн дурын шинж чанартай баримт бичиг болно. Зөвлөмж нь заавал дагаж мөрдөх хууль биш. Зөвлөмж нь хүчин төгөлдөр байгаа үндэсний болон олон улсын хууль, үүрэг хариуцлага, гэрээ, хэлцлүүдийг орлохгүй болно. Мөн түүнчлэн улс орнуудын олон улсын хуулийн дагуу хүлээсэн үүргийг хязгаарлахгүй буюу тэдгээрийг зөрчихгүй болно.

“Зөөлөн хууль” нь холбогдох олон улсын гэрээ хэлэлцээрүүдтэй харьцуулахад улс орнуудын хувьд тохиролцоонд хүрэхэд илүү хялбар байдгаараа давуу талтай юм. Мөн түүнчлэн зөөлөн хууль нь илүү цогц, илүү дэлгэрэнгүй байж болдог учир мэргэжлийн асуудлуудыг нарийн тусгахад илүү тохиромжтой, эдэлбэрийн засаглалын гэх мэт шилдэг туршлагаудыг түгээн дэлгэрүүлэхэд илүү тохиромжтой байдаг. ХХААБ-ын “зөөлөн хуулийн” арга хэрэгслийг ашигласан туршлагаас харахад тэдгээр нь олон орны үндэсний бодлого, хууль тогтоомжийг боловсруулахад зөв удирдамжаар хангаж эерэг нөлөө үзүүлж байна. Улс орон олон улсын зөөлөн хуулийн актыг бүрнээр нь болон хэсэгчлэн хэрэгжүүлж эхлэхэд “зөөлөн хууль” нь тухайн орны хүрээнд заавал мөрдөх “хатуу хууль” болон хувирдаг.

бүхий л үйл ажиллагаа, үндэсний болон олон улсын хуулиар хүлээсэн түүний хүчин төгөлдөр үүрэг, зохих бүсийн болон олон улсын баримт бичгийн дагуу сайн дурын үндсэн дээр хүлээсэн амлалтуудтай нь нийцэж байх ёстойг анхааруулсан байдаг. Зөвлөмжийн дагуу эдэлбэрийн засаглалыг сайжруулах зорилгоор хэрэгжүүлж буй бүх хөтөлбөр, бодлого болон эл зорилгоор үзүүлж байгаа мэргэжлийн туслалцаа нь улс орнуудын олон улсын хуулийн дагуу хүлээсэн хүчин төгөлдөр үүрэг хариуцлагатай нь нийцсэн байх хэрэгтэй.

## Зөвлөмжийг хэн ашиглах вэ?

Хүн бүр эдэлбэрийн засаглалыг сайжруулахад тодорхой үүрэг хүлээх учиртай. Зөвлөмжийг янз бүрийн хүмүүс, байгууллагууд янз бүрээр ашиглаж болох ба мөн бусадтай түншлэх хэлбэрээр ашиглах боломжтой.

### Төр

Төр бодлого, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, биелэлтийг хангахад онцгой үүрэгтэй ба шүүх үйл ажиллагаа, эдэлбэрийн эрхийн бүртгэл, үнэлгээ, татвар ноогдуулалт, орон зайн төлөвлөлт хийх зэргээр дамжуулан бодит удирдлагаар хангадаг.

### Шүүх эрх мэдэл болон засгийн газрын агентлагууд

Эдэлбэрийн удирдлагын асуудал хариуцсан шүүх эрх мэдлийн болон засгийн газрын агентлагууд бүх хүмүүст түүний дотор алслагдсан орон нутагт амьдарч байгаа иргэдэд эрх тэгш үйлчилгээ үзүүлэхийг эрмэлзэх нь зүйтэй. Үйлчилгээг шуурхай, үр дүнтэй, ямар нэгэн хээл хахууль харалгүйгээр үзүүлэх ёстой.

### Хувь хүмүүс, нутгийн иргэд

Эдэлбэрийн эрх эзэмшиж буй хүмүүс, нутгийн иргэд болон бусад этгээд өөрсдийн эрхээ мэддэг байхын зэрэгцээ бусдын авилгач зан үйлээс өөрсдийгөө хэрхэн хамгаалах талаар мэддэг байх хэрэгтэй.

### Иргэний нийгэм

Иргэний нийгмийн байгууллагууд эдэлбэрийн эрхийн талаар хүмүүст тайлбарлан таниулж, эрхээ эдлэж, хамгаалах талаар тэдэнд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа явуулж болно. Мөн шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог дэмжин ажиллаж болно.

### Хөрөнгө оруулагчид

Хөрөнгө оруулагчид өөрсдийнх нь хийсэн хөрөнгө оруулалт хүмүүсийн эдэлбэрийн эрхийг алдагдахад хүргэхгүй байх тал дээр анхаарах үүрэгтэй. Тэд газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн эрх авахаар хүсэлт гаргахдаа холбогдох бүх хүмүүст мэдэгдэж, зөвшилцөлд оролцох боломжоор хангах ёстой.

### Эдэлбэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд

Мэргэжилтнүүд (тухайлбал судлаач, хуульч, нотариатч, үнэлгээ хийгч, орон зайн төлөвлөгчид) хүлээсэн үүргээ шударгаар, ёсчлон гүйцэтгэх зэрэг ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх үүрэгтэй.

### Эрдэмтэн, судлаачид

Их дээд сургуулиуд эдэлбэрийн засаглалын холбогдолтой асуудлыг сургалтын хөтөлбөртөө тусгаж, заах арга, судалгаан ажлын хүрээнд хамтын ажиллагаагаа бэхжүүлж болно.

## Зөвлөмжийг хэрхэн боловсруулсан бэ?

Энэхүү зөвлөмжийг Дэлхийн Хүнсний Аюулгүй Байдлын Хорооноос 2012 оны 5-р сард албан ёсоор баталсан болно. ДХАБХ нь дэлхийн хүнсний аюулгүй байдалтай холбоотой бодлогуудыг хянан хэлэлцэж, мөрдүүлэх үүрэг бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллагын дээд форум юм. Зөвлөмжийн бичвэрийг 2011 оны 7, 10-р сар, 2012 оны 3-р сард ДХАБХ-оос тэргүүлэн зохион байгуулсан засгийн газар хоорондын яриа хэлэлцээрээр эцэслэн баталсан.

Эдэлбэрийн засаглалын хүрээнд дэлхийн хэмжээний өөрчлөлт хийхээр хамтран ажиллаж байгаа олон улсын, бүсийн болон үндэстний хэмжээний төрөл бүрийн байгууллагуудын дэлхий даяарх түншлэлийн үндсэн дээр Зөвлөмжийг боловсруулсан.

### ЗӨВЛӨЛДӨХ ЧУУЛГАН

2009  
2010

- Бүсийн 10, хувийн хэвшлийн нэг, иргэний нийгмийн байгууллагуудын 4 удаагийн зөвлөлдөх уулзалтыг 2009 оны 9-р сараас 2010 оны 11-р сарын хооронд зохион байгуулсан. Эдгээр уулзалтанд дэлхийн 130 гаруй орны 1000 гаран төлөөлөгч оролцсон. Оролцогсод төрийн байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, НҮБ-ын агентлагуудыг төлөөлж байв. Зөвлөлдөх уулзалт бүрээс эдэлбэрийн засаглалын хүрээнд Зөвлөмжид тусгах шаардлагатай асуудлууд, арга хэмжээг тодорхойлон үнэлэлт дүгнэлт өгч байв.

### ЯРИА ХЭЛЭЛЦЭЭ

2011  
2012

- Зөвлөлдөх уулзалтуудын төгсгөлд эх хувилбарыг бэлтгэж, 2011 оны 4, 5-р сард цахим зөвлөгөөн зохион байгуулсан.
- Эхний төсөлд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачдаас дэвшүүлсэн саналуудыг тусгасан.
- 2011 оны 7, 10-р сар, 2012 оны 3-р сард ДХАБХ –оос зохион байгуулсан засгийн газар хоорондын яриа хэлэлцээрээр Зөвлөмжийн эцсийн хувилбарыг бэлэн болгосон.

### ЗӨВЛӨМЖ БАТАЛСАН

2012

- Зөвлөмжийг ДХАБХ- ны 2012 оны 5-р сарын 11-ний өдрийн Гучин наймдугаар (тусгай) чуулганаар баталсан.





Энэхүү гарын авлагад *“Үндэсний хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн хариуцлагатай засаглалын сайн дурын зөвлөмж”*-ийг тоймлон үзүүлсэн. Энд Зөвлөмжийн шинж чанар, зорилго, агуулга болон хэн ашиглаж болох талаар тайлбарласан. Энэхүү гарын авлагад эдэлбэр гэж юуг нэрлэж байгаа тухай болон эдэлбэрийн засаглалыг сайжруулах нь хэрхэн өлсгөлөн ядуурлыг арилгаж, байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтад түлхэц болох тухай тайлбарласан.